



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2025 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот

Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам
(ИОНН)-ын дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг
бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, Н.Батзориг, М.Батсуурь, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Н.Баярмаа, Э.Золзаяа, Ц.Оч, Б.Ундрах, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, М.Пүрэвсүрэн, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ын дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч Н.Батзоригийн танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ыг төлөөлж тус намыг үүсгэн байгуулагч Ц.Оюунгэрэлээс “ИОНН нь намын дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг Ээлжит бус гуравдугаар Их хурлаараа дахин дэлгэрэнгүй хэлэлцүүлэн Улсын дээд шүүхэд хүргүүлсэн. Гэвч тус шүүхээс зөрчил арилаагүй хэвээр байна гэж үзэж 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр албан бичгээр буцаасныг дахин авч хэлэлцээд, 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр намынхаа Төлөөллийн төв байгууллагаараа хэлэлцүүлж нэмэлт, өөрчлөлт оруулсан. Иймд Улс төрийн намын тухай хуульд нийцүүлж баталсан ИОНН-ын дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг бүртгэлд бүртгэж өгнө үү” гэсэн өргөдлийг нийт 148 хуудас материал, 1 ширхэг флашны хамт 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Улсын дээд шүүхэд ирүүлсэн байна.

Дээрх өргөдөл, хавсралтаар ирүүлсэн баримтуудыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын дагуу Бүртгэлийн алба шалгаж, ирүүлснийг өргөдөл, түүнд хавсаргасан баримт тус бүрийг нягтлаад нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ын дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг дараах үндэслэлээр бүртгэж шийдвэрлэлээ.

Нэг.Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ.” 17.2.1-д “намын дүрэм, хөтөлбөрийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж, Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор бүртгэсэн Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ын хүчин төгөлдөр байгаа дүрмийн 9.1-д “Намын эрх барих дээд байгууллага нь Их хурал байна”, 9.2-т “Дараах асуудлыг зөвхөн намын Их хурлаар хэлэлцэн шийдвэрлэж батална:”, 9.2.1-д “Намын дүрэм, мөрийн хөтөлбөр, бүтэц зохион байгуулалт” гэж тус тус заасан.

Өргөдөл, түүнд холбогдох баримтуудаас үзвэл, Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ын 2025 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн дэлгэрэнгүй хэлэлцүүлэгтэй хуралдсан ээлжит бус гуравдугаар Их хурлын 04 дүгээр тогтоолоор ИОНН-ын дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг баталж, Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр ирүүлсэн байх бөгөөд хурлын процессын хувьд зөрчилгүй боловч дүрмийн зарим заалт нь Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д нийцээгүй буюу өмнөх тогтоолын алдаа зөрчил бүрэн арилаагүй гэж 7 үндэслэл бүхий 14 зөрчлийг дурдан Улсын дээд шүүхийн 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 02/3559 дугаартай албан бичгээр буцаасан байна.

Хоёр.Дээрх албан бичгийн дагуу 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ын төлөөллийн төв байгууллага болох Төлөөлөгчдийн Танхимын гуравдугаар хурал хуралдаж, намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн баталсан, энэ тухай холбогдох баримтыг шалгахад Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д нийцжээ. Тодруулбал,

2.1.Улсын дээд шүүхэд бүртгэлтэй Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ын дүрмийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Намын дарга нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:”, 13.3.2-т “Төлөөлөгчдийн Танхим, Үнэт зүйлийн хорооны хурлыг товлон зарлах, удирдах ...” гэж заасны дагуу тус намын даргын 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 01/21 дүгээр албан бичгээр Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ын Төлөөлөгчдийн Танхимын гуравдугаар хурлыг товлон зарлаж, улмаар Төлөөлөгчдийн Танхимын гуравдугаар хурал 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр танхим болон цахим хэлбэрээр хуралдсан бөгөөд тус хуралд сонгогдсон 103 төлөөлөгч оролцохоос танхимаар 10, цахимаар 69 нийт 79 төлөөлөгч оролцсон болох нь өргөдөлд хавсарган ирүүлсэн 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн ирцийн бүртгэл, фото зураг, дүрс бичлэг болон бусад баримтаар тогтоогдож байх тул тухайн хурлын процесс зөрчигдөөгүй байна.

2.2.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.4-т Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна” гэж;

Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ын дүрмийн 25 дугаар зүйлийн 25.11-д “Намын дотоод сонгууль, намын хурлын шийдвэрийн санал хураалт нь цахим систем ашиглан, цаасаар, гар өргөж саналаа өгөх гэсэн горимын аль нэгээр явагдана”, 25.12-т “Хурлын шийдвэр, сонгуулийн үр дүн нь санал хураалтад оролцсон гишүүдийн энгийн олонхын саналаар батлагдана” гэж тус тус заажээ.

Иргэдийн Оролцооны Нэгдэл Намын дүрэм (шинэчилсэн найруулга)-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг Төлөөлөгчдийн Танхимын хурлаар хэлэлцэх эсэх талаар явуулсан ил санал хураалтад “ИОНН” аппликейшн ашиглаж, 79 гишүүн буюу 76.7% нь дэмжсэн санал өгсөн болох нь тус намын Тооллогын комиссын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01, 02 дугаар тогтоол, хурлын тэмдэглэл болон бусад бичгийн баримтаар тогтоогдож байна.

2.3.Өмнөх, Улсын дээд шүүхийн 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 02/3559 дугаартай албан бичгээр буцаасан ИОНН-ын дахин, дэлгэрэнгүй хэлэлцүүлэгтэй хуралдсан ээлжит бус гуравдугаар Их хурлын 04 дүгээр тогтоолоор баталсан намын дүрэм (Шинэчилсэн найруулга) нь 5 бүлэг, 30 зүйл, 489 заалттай байсан, үүний 15.8 хувь болох 1 зүйл, 82 заалтад Төлөөлөгчдийн Танхимын гуравдугаар хурлын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан нь Улс төрийн намын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т заасантай нийцэж байна.

Иймээс, Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ын дүрэм нь бүхэлдээ Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан намын дүрэмд тавигдах нийтлэг шаардлага болон намын дүрмээр тусгайлан зохицуулах асуудлыг тусгасан байх тул бүртгэх хууль зүйн үндэслэлтэй байна.

Гурав.Намын дүрмийн 10.8.3-т “Намын Төлөөлөгчдийн танхим болон Маргаан Таслах Комиссын тайланг гурван жил тутам хэлэлцэх, тэдгээрийн бүрэлдэхүүнийг нууц санал хураалтаар сонгох, чөлөөлөх, ...” гэж заасан атлаа нөхөн сонгох асуудлыг орхигдуулсан, энэ талаар Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ын 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 1/17 дугаар албан бичгээр “... “чөлөөлөх” гэдэг үгийн ард батлагдсан” нөхөн сонгох” гэдэг үгийг орхиж шивсэн байна. Тус дүрмийг батлахдаа ИОН намын аливаа сонгуульт байгууллагын бүрэлдэхүүнийг сонгох, чөлөөлөх эрх бүхий этгээд нь мөн тэдгээрийн бүрэлдэхүүнийг “нөхөн сонгох” эрх мэдэлтэй байхаар хэлэлцэж баталсан бөгөөд зөвхөн 10.8.3 дахь заалт дээр орхиж шивсэн байна” гэх тайлбарыг ирүүлсэн байх тул тухайн заалтыг зөрчилгүй, засагдах боломжтой гэж үзлээ.

Мөн сонгуульт гишүүний татварын тухай заалт дүрэмд оруулаагүй талаар ИОНН “... Сонгуульт гишүүний татвартай байх эсэх асуудлаар нам дотор хэлэлцүүлэг хийж, ... гишүүдийн оролцоог багасгах нөхцөл үүсгэх нэмэлт татварыг албадан авахгүй байх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн. Хэдийгээр сонгуульт гишүүний татвар ИОН намд байхгүй ч улс төрийн хуримтлал бүрдүүлэгч гишүүний татвар хэмээх албадлагын бус, сайн дурын үндсэн дээр төлдөг татварын хэлбэрийг манай нам анхнаасаа хэрэглэж ирсэн” гэсэн тайлбар ирүүлснээс үзэхэд Улс төрийн намын тухай хуулийн 32.3-т заасантай зөрчилдөхгүй гэж үзэв.

Дээрх байдлаас үзэхэд, Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ын 2025 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн ээлжит бус гуравдугаар Их хурлын 04 дүгээр тогтоолоор баталсан намын дүрэм (Шинэчилсэн найруулга)"-д нэмэлт өөрчлөлт оруулсан Төлөөлөгчдийн Танхимын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн гуравдугаар хурлын 03 дугаар тогтоол нь Улс төрийн намын тухайн хууль (Шинэчилсэн найруулга)-д нийцэж байх тул тус намын дүрмийн шинэчилсэн найруулгыг бүхэлд нь бүртгэх нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь заалтыг баримтлан Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН)-ын дүрэм (Шинэчилсэн найруулга)-ийг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Н.БАТЗОРИГ